



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/564

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "г" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад Буянт, Мянгад сумын иргэдээс ирүүлсэн тус нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж байна гэх мэдээллийн дагуу дурдагдсан асуудлыг шалган, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Х.Баасанхүү- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн

гишүүд: Г.Ганзориг - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч

Б.Түвшинбаяр- Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад

Э.Амарбаясгалан- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Э.Цогтсайхан - Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Өргөдөлд дурдагдсан асуудлыг хууль тогтоомжийн дагуу шалган дүгнэлт гаргаж 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ